

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

“Монгол Орны Газарзүй, Геоэкологи Сэтгүүл (Mongolian Journal of Geography and Geocology) бүтээлийн 43 дэх дугаарыг уншигч олон та бүхэнд хүргэж байна. Энэхүү эрдэм шинжилгээний бүтээлд газарзүй, геоэкологи, орчин судлал, байгалийн нөөц, уур амьсгалтай холбоотой суур судалгаануудын онцлох шинэлэг үр дүн, байгаль орчны менежмент, төлөвлөлт, хамгаалал, нөхөн сэргээлт, үнэлгээний чиглэлийн хэрэглээний судалгааны үр дүнгүүдийг тэртээ 60 жилийн өмнөөс хэвлэж, эрдэм мэдлэг сонирхогч хэн бүхний оюуны мэлмийд хүргэсээр ирсэн түүхтэй.

Бүтээлийн чанар, ач холбогдлыг өсгөх, олон улсын түвшний эрдэм шинжилгээний сэтгүүл болгох тал дээр Хүрээлэнгийн эрдмийн зөвлөл, сэтгүүлийн редакцын зөвлөл онцгойлон анхаарч сүүлийн жилүүдэд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна. Тухайлбал, 2017 оноос сэтгүүлийг хэвлэмэл хувилбараас гадна цахим (www.mjgg.igg.ac.mn/) хэлбэрээр уншигч олонд хүргэж эхэлсэн; 2019 оноос ISSN дугаарт бүртгэжүүлсэн; 2021 оноос “Монгол Орны Газарзүй, Геоэкологи Сэтгүүл, англиар Mongolian Journal of Geography and Geocology” нэртэй болгож, олон улсын түвшинд гаргах зорилгоор өгүүлэл хүлээн авах, түүнд хийх хөндлөнгийн хянан магадалгааг олон улсын жишиг стандартын дагуу гүйцэтгэх, хэвлэн нийтлэхтэй холбоотой журмыг шинэчлэн боловсруулсан зэргийг дурдаж болно. Энэ жилийн дугаараас эхэлж бүтээлийг DOI дугаартай болгож, Google Scholar хайлтын системд хайгдах хэлбэрт шилжүүлээ. Ингэснээр зохиогчийн өгүүлэл олон улсын түвшинд жинхэнэ утгаараа гарч бусад орны судлаачдад ашиглах боломж олгох, бүтээлээс авах эшлэлийн тоог эрс нэмэгдүүлэх давуу талтай юм. Мөн энэ дугаарыг “Mongolia Journals Online” төслийн шинжлэх ухааны сэтгүүлийн жагсаалтад албан ёсоор оруулж байгаагаараа чухал үйл явдал болж байна.

Монгол Орны Газарзүй, Геоэкологи Сэтгүүлийн 43-р дугаарт 45 өгүүлэл хүлээн авснаас сэтгүүлийн шалгуурыг хангасан 26 өгүүллийг хэвлэж, эрхэм уншигч олон, эрдэмтэн судлаач та бүхэндээ хүргэж байна. Эрдэм шинжилгээний өгүүллээ ирүүлсэн эрдэмтэн судлаачид та бүхэнд бүтээлийг эрхлэх зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлье.

Эрхэм баян эрдэм мэдлэг түгэн дэлгэрэх болтугай.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн захирал, сэтгүүлийн ерөнхий эрхлэгч, доктор А.Дашцэрэн

<https://doi.org/10.5564/mjgg.v59i43.2506>